



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 8/26

Мандалговь

Г Албан тушаалын тодорхойлолтын
төсөл боловсруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 32 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, бэлтгэл ажил хангахыг Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн (Р.Мөнхбаясгалан)-д үүрэг болгосугай.

2. Албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулахад ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлд 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн (Р.Мөнхбаясгалан)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЛТАНТӨГС

